

“БХИС-ийн багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцож, үнэлэх журам”-ын танилцуулга

Сургуулийн сургалт хариуцсан дэд захирлын удирдамж чиглэл, зааврын дагуу СБЗА-наас энэхүү журмыг шинээр боловсруулав.

1. “Журам”-ын эрх зүйн орчин

“Дээд боловсролын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалт, БСШУ-ны сайдын 2003 оны 139, 158, 2008 оны 187 дугаар тушаалуудаар батлагдсан зааврууд, мөн сайдын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26 дугаар тушаалын 2.3.1 дэх заалт, БХИС-ийн дүрэм, “Хөгжлийн мастер төлөвлөгөө” зэрэг эрх зүйн баримт бичгүүд энэхүү журмыг боловсруулах эрх зүйн орчинг бүрдүүлж байна.

2. “Шинэ журмын онцлог

- Багш, мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулиуд болон БХИС-ийн хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээний ажлын менежментийг сайжруулах замаар **багшийн хийж байх ажлыг** тодорхой болгож тэдгээрт харгалзах кредит цагийг тооцох аргачлалыг тодорхой болгосон.

- Багшийн гүйцэтгэх “А”, “Б”, “В” цагийн ногдлыг сургалтын ажил бүрээр тодорхой тусгаж өгсөн.

- Кредит цагаар тооцох боломжгүй ажлын ажил үйлчилгээний хөлсийг тухай бүрт нь цагаар бодож олгож байхаар журамласан.

- Багшийн гүйцэтгэсэн илүү цагт олгох хөлсний хэмжээг шатлал бүрээр тодорхой тусгасан бөгөөд түүнийг жил бүр БХИС-ийн захирлын тушаалаар тодотгож байхаар журамласан.

3. Шинэ журмыг хэрэгжүүлснээр гарах үр дүн, үр нөлөө

- Багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлт тодорхой болж чанар, гүйцэтгэл, үр дүн нь сайжирна.

- Багшаас гүйцэтгэх сургалт, эрдэм шинжилгээний ажилд инноваци, шинэ технологи эрчимтэй нэвтэрнэ.

- Сонсогч, оюутан төвтэй сургалтын арга, технологид шилжихэд дэмжлэг үзүүлнэ.

- Тэнхим, бүрэлдэхүүн сургуулиудын сургалт, эрдэм шинжилгээний ажлын менежментэд шинэ дэвшил гарч багшийн ажлыг төлөвлөсөн хэмжээгээр бус бодит гүйцэтгэл, үр дүнгээр хэмждэг болсноор ажлын чанарт ахиц гарна.

- Мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургууль, төвийн удирдлага-менежментийн чадавхи дээшилнэ.

Сургалтын бодлого зохицуулалтын алба

БХИС-ийн багшийн сургалт-эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцож үнэлэх журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Шинжлэх ухаан, дээд болон мэргэжлийн боловсролын хөгжлийн нийтлэг чиг хандлага, шаардлагад сургалт, эрдэм шинжилгээний ажлыг нийцүүлэх, БХИС-ийн хөгжлийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж сургалт, эрдэм шинжилгээний ажлын нэгдлийг хангах, сургалтын технологийг шинэчлэх, чанарыг дээшлүүлэх чиглэлээр профессор багш (цаашид “багш” гэнэ) нарын **сургалт, эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлж тооцоход** энэхүү журмын зорилго оршино.

1.2. БХИС-ийн багшийн эрдэм мэдлэг, сурган боловсруулах ур чадварт тавигдах стандартыг хангаж биелүүлэх, ажлын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, чанар, үр дүнгээр урамшуулах, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, багшийг бүх талаар хөгжүүлж хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн-судлаач болоход энэхүү журам үйлчилнэ.

1.3. Цэргийн мэргэжлээр **диплом, бакалавр, магистр, докторын** боловсрол олгох болон **мэргэжлийн** сургалтын агуулга, технологийн залгамж холбоог хангах, багшийн гүйцэтгэсэн сургалт, эрдэм шинжилгээний ажил, суралцагчдад үзүүлэх үйлчилгээ, сургууль олон нийтийн болон бусад ажлыг **кредит цагаар** үнэлэх зохистой харьцааг энэ журмаар зохицуулна.

Багшийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон бусад ажил үйлчилгээний танхимийн **48 цагийг 1 багц** цагт тооцно.

Хоёр.Багшийн ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцох

2.1. Багш нь дараах чиглэлийн ажил үйлчилгээг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

А. Сургалт, заах арга зүйн ажил (танхимийн сургалт)

Б. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил

В. Мэргэжлийн болон сургууль, олон нийтэд үзүүлэх ажил үйлчилгээ.

2.2. Багшийн хөдөлмөрийг кредит тогтолцоонд нийцүүлэн багц цагаар үнэлэх ба “**А**”, “**Б**”, “**В**” цагийн ажлын нийт гүйцэтгэл нэг хичээлийн жилд **30 кредит** цаг байхаар төлөвлөнө. Багшийн өдрийн хэлбэрээр заасан **танхимийн** сургалтын 1 багц цагийн хэмжээ нь тухайн хичээлийн онцлогоос хамаарч **24-48** танхимийн цаг байна. **Эчнээ** болон **зайн** сургалтын танхимийн цаг нь **12-24 танхимийн цаг** байна.

2.3. Доктор, магистрын зэрэг эзэмшүүлэх сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн хөтөлбөрийн агуулгын 50 хувийг өдрийн хэлбэрээр, 25 хувийг эчнээ хэлбэрээр, үлдсэн хэсгийг багшийн чиглэл, туслалцаатайгаар бие даан судалж эзэмшүүлэхээр төлөвлөнө. Хичээл нь ихэвчлэн **онолын семинарт** суурилсан хэлбэртэй байна.

2.4. Багшийн танхимд гүйцэтгэх сургалтын ажлыг “**А**”, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг “**Б**”, мэргэжлийн болон сургалт заах арга зүйн нэмэлт ажлыг “**В**” цаг гэж ангилан албан тушаалын шатлалаас хамаарч нэг хичээлийн жилд гүйцэтгэх цагийг доорх хэлбэрээр төлөвлөн тооцно.

Багшийн жилд гүйцэтгэх кредит цагийн норм

а/ Багшийн албан тушаалын зэрэглэл	Танхимийн сургалт "А"	Эрдэм шинжилгээ "Б"	Мэргэжил, заах арга зүйн нэмэлт ажил "В"
Профессор	13	7	10
Дэд профессор	14	6	10
Ахлах багш	15	5	10
Багш	16	4	10
Дадлагажигч багш	14	4	12
Дадлагын багш	10	2	3
Бүрэлдэхүүн сургуулийн захирал	5	5	2
Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал, сургалтын албаны дарга	6	5	2
Тэнхимийн дарга, эрхлэгч	6	6	4
б/ Хичээл заах эрх бүхий албан тушаалтан			
БХИС-ийн чиглэл хариуцсан дэд захирлууд, БХЭШХ-ийн захирал	1		-
ЭШДМСА, СБЗА-ны дарга болон	2		-
Албадын дарга нар	СБЗА, ЭШДМСА-тай гэрээ байгуулж хөлс тооцуулан хичээл заана		
БХЭШХ-гийн дэд захирал, төвийн дарга, судлаачид	СБЗА, ЭШДМСА-тай гэрээ байгуулж хөлс тооцуулан хичээл заана		
ЭШДМС, СБЗА-ны мэргэжилтэн, бүрэлдэхүүн сургуулийн ЭШСА-ны арга зүйч багш нар	2	2	
Соёлын төвийн зааварлагч	2		-

2.5. **Дадлагажигч багшид илүү цаг тооцохгүй**, тэрээр тусгай төлөвлөгөөтэй ажиллаж богино хугацаанд багш болон төлөвших, сургах арга зүйн сургалтанд сууж багшлах эрхийн гэрчилгээ авах үүрэг хүлээнэ.

2.6. Тэнхимийн дарга, эрхлэгчид, багш нарын сургалтын ажлын төлөвлөгөөг үндэслэн хавсралт 1-ээр тэнхимийн гүйцэтгэх ажлын төлөвлөлт, хуваарилалтыг хийж, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаар хянуулж их сургуулийн Сургалт хариуцсан дэд захирлаар батлуулна.

2.7. Сургалтын цагийн лекц, семинар, дадлага, бүлгийн дасгал, лаборатори, бие даалтын харьцааг тухайн хичээлийн батлагдсан хөтөлбөрт стандартын дагуу тодорхой зааж түүнд нийцүүлэн хичээлийг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлийг тооцно.

**Багшийн хөдөлмөрийн “А” цаг
(Танхимийн сургалт)**

Лекц, семинар, дадлага, бүлгийн дасгал, лабораторийн хичээлээс хамааран багшийн сургалтын /”А”/ цагийн ноогдлыг дараах байдлаар төлөвлөж гүйцэтгэлийг тооцно. Үүнд:

1. Багшийн заасан лекцийн хичээлийн 16 цагийг 1 кредит цагт тооцно. Лекц унших багш нь мэрэгжлийн, мэргэшүүлэх хичээлийн хувьд ахлах багш, түүнээс дээш албан тушаалын зэрэглэлтэй байх шаардлага тавина.

2. Семинарын хичээлийн танхимийн 32 цагийг 1 кредит цагт тооцно. Семинарын хичээлийг 30, гадаад хэл, дадлага, бүлгийн дасгал, лабораторийн хичээлийг 20 сонсогч оюутнаар бүлэглэнэ.

3. Лаборатори, сургалтын дадлагын хичээлийг 15-20 хүнээр зохион байгуулах бөгөөд багшийн гүйцэтгэсэн танхимийн 48 цагийг 1 кредит цагт тооцно. Биеийн тамир, гадаад хэлний хичээл энэ ангилалд багтана.

4. Багшаас сонсогч, оюутны бие даалтын ажлыг удирдсан танхимийн 48 цагийг 1 кредит цагт тооцно. Багшаас сонсогч, оюутны бие даалтыг удирдах цагийг багш, тэнхим заавал графикаар төлөвлөсөн байх бөгөөд хэмжээ нь тухайн хичээлийн танхимд орох цагийн 20 хувиас хэтрэхгүй байна. **Энэ ажилд олгогдох кредит цагийг багшийн “В” цагт тооцно.**

5. Эчнээ болон зайны сургалтанд хичээл заасан багшид олгогдох кредит цагийг дээрх журмаар тооцно.

6. БХИС-ийн захирлын тушаалаар сонсогч, оюутны танилцах дадлагыг ажлын 15 хоног удирдахад сонсогч оюутан тутамд 0.05 кредит цаг, мэргэжлийн болон мэргэшүүлэх /үйлдвэрлэлийн/ дадлагыг ажлын 15 хоног хүртэл удирдахад сонсогч, оюутан тутамд 0.1 кредит цаг тус тус тооцно.

7. Сургалтын төлөвлөгөөнд заагдсан мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлээр ангийн ажил, төсөл, график тооцооны ажил удирдаж хамгаалуулахад ажил тутамд 0.1 кредит цаг тус тус тооцно. /Нэг багш 10-аас илүү ажил удирдахгүй бөгөөд хэрэв илүү гарсан бол “В” цагт шилжүүлэн тооцно/

8. Хөгжимдөх ур чадварын ганцаарчилсан хичээлийг 2-5 сурагчтай явуулсан ЦХС-ийн багшид сурагч тус бүрт 0.05 кредит цаг буюу танхимын 32 цагийг 1 багц цагаар тооцно. /Хичээл бүрт/

9. Эчнээгээр суралцагч оюутны даалгавар боловсруулж, уншиж үнэлэхэд ажил тутамд 0.03 кредит цаг тооцно.

10. Сонсогч, сурагч, оюутныг шавь сургалтаар сургах /хүн тус бүрт 0.1 кредит цаг/

**Багшийн хөдөлмөрийн “Б” цаг
(Эрдэм шинжилгээний болон зохион бүтээх ажил)**

Хүснэгт 2.

1. Эрдэм шинжилгээний бүтээл

дд	Тооцох ажлын хэлбэр, үзүүлэлт	Олгогдох кредит (max)	Ажлын хөлс тооцох хэлбэр
1.	Нэг сэдэвт зохиол бичих	1хх-ыг 2 кредитээр тооцож гэрээ байгуулан хөлс тооцуулна	
2.	Докторын диссертац /нэг ажил/	2.0 кр.цаг	Хөлс тооцохгүй
3.	Магистрын ажил /нэг ажил/	1.5 кр.цаг	Хөлс тооцохгүй
4.	Сурах бичиг бүтээж хэвлүүлсэн бол /сургуулийн захиалгаар/	1хх-ыг 2 кредитээр тооцож гэрээ байгуулан хөлс тооцуулна	
5.	Мэргэжлийн сурах бичигт шинжээчийн дүгнэлт гаргах	1хх-ыг 0.1 кредитээр тооцно	

6.	Цэргийн үлээвэр найрал хөгжимд зориулсан том хэмжээний бүтээл туурвих	2.0 кр.цаг	Хөлс тооцохгүй
7.	Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу хөгжмийн бэсрэг бүтээл туурвих	Бүтээл тус бүрт 1.0 кр.цаг	Хөлс тооцохгүй
8.	Тухайн жил докторын зэрэг хамгаалсан бол	3.0 кр.цаг	Хөлс тооцохгүй
9.	Багшаас заадаг хичээлийн тодорхойлолтыг бэлтгэж буй мэргэжилтний загварын дагуу гаргаж түүнд нийцүүлэн хичээлийн хөтөлбөрийг шинээр боловсруулж, хичээлийн сэдэв бүрийн дэлгэрэнгүй агуулга, сонсогч, оюутны бие дааж гүйцэтгэх ажлын арга зүйн зөвлөмж, бодлого, даалгавар, өөрийгөө шалгах асуулт зэргийг багтаасан гарын авлага бүтээсэн бол	х.х. тутамд 1.0 кр.цаг тооцно.	Хөлс тооцохгүй

2. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, хурал.

10	Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих, хэлэлцүүлэх (илтгэл тутамд) - олон улсын хэмжээнд - улсын хэмжээнд - БХИС-ийн хэмжээнд - бүрэлдэхүүн сургуульд - мэргэжлийн тэнхимд (багш нарын хамтын бүтээлд кредит цагийг хувааж тооцно)	1.0 кр.цаг 0.8 кр.цаг 0.5 кр.цаг 0.3 кр.цаг 0.2 кр.цаг	
11	Мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх (өгүүлэл нэг бүрт) - олон улсын хэмжээнд - улсын хэмжээнд - БХИС-ийн хэмжээнд - бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд (багш нарын хамтын бүтээлд кредит цагийг хувааж тооцно)	1.5 кр.цаг 1.0 кр.цаг 0.6 кр.цаг 0.4 кр.цаг	
12	Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах (хурал бүрт) - олон улсын хэмжээнд - улсын хэмжээнд - БХИС-ийн хэмжээнд - бүрэлдэхүүн сургуульд - мэргэжлийн тэнхимд багш нар хамтран зохион байгуулбал ногдох кредит цагийг хувааж олгоно.	1.5 кр.цаг 1.0 кр.цаг 0.8 кр.цаг 0.5 кр.цаг 0.3 кр.цаг	
13	Эрдэм шинжилгээний хуралд багш, сонсогч, оюутны илтгэл удирдаж тавиулбал - улсын хэмжээнд - салбарын хэмжээнд	1.5, 1.2, 1.0, 0.5 кр.цаг 1.0, 0.8, 0.6, 0.4 кр.цаг 0.8, 0.6, 0.4, 0.2 кр.цаг	

	- БХИС-д - Бүрэлдэхүүн сургуульд - Мэргэжлийн тэнхимд	0.6, 0.5, 0.3, 0.1 кр.цаг 0.4, 0.3, 0.2, 0.1 кр.цаг	
--	---	--	--

Тайлбар: Удирдаж тавиулсан илтгэл нь 1.2.3 дугаар байр эзэлсэн бол эхний 3 оноог байрын дарааллаар, илтгэл удирдсан бол сүүлийн кредит цагийг олгоно.

3. Гэрээт, төсөлт болон бусад ажил

Хүснэгт 3.

14	Онолын суурь судалгаа гүйцэтгэж байгаа бол (үр дүнгээр нь)	1.5 кр.цаг	
15	ШУТ-ийн төсөлт ажил гүйцэтгэж байгаа бол (үр дүнгээр нь)	1.5 кр.цаг	
16	ШУТ-ийн гэрээт ажил гүйцэтгэж байгаа бол (сургуульд мөнгөн орлого оруулсан тохиолдолд багшийн цагийн ачааллыг хөнгөлөх, урамшуулал олгох асуудлыг БХИС-ийн захирал шийдвэрлэнэ)	1.0 кр.цаг	Ажлын хөлс олгож болно.
17	Баталгаажуулсан патент, ашигтай загвар (хамтран гүйцэтгэсэн бол кредит цагийг хувааж тооцно)-ын гэрчилгээ авсан бол.	1.0 кр.цаг	
18	Бусад их, дээд сургууль, ЭШ байгууллагатай хамтарсан судалгаа хийж байгаа бол (эхлэл, явц, үр дүнгээр нь тооцно)	0.3-1.0 кр.цаг	
19	Багаж, зэвсэг, төхөөрөмж зохион бүтээж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн, үр дүнгээр	1.0 кр.цаг	Сургууль худалдаж авч болно.

4. Магистр, докторын судалгааны ажил удирдаж хамгаалуулах

Хүснэгт 4.

1	Магистрын ажил удирдаж хамгаалуулах	2 + 3 = 5 кр.цаг
2	Магистрын ажилд шүүмж өгөх	1.0 кр.цаг
3	Докторын диссертац удирдаж хамгаалуулах	2 + 3 + 4 + 3 = 12 кр.цаг
4	Докторын диссертацд шүүмж бичсэн	2.0 кр.цаг
5	Докторын ажлын зөвлөхөөр ажиллах	1+1 = 2 кр.цаг

Тайлбар: Докторын диссертац, магистрын ажил удирдаж хамгаалуулсан кредит цагийг тооцохдоо: сургалтын төлөвлөгөний биелэлт, шалгалтын болон аттестатчиллын дүн, докторантын бичиж нийтлүүлсэн судалгааны өгүүлэл, докторын диссертац, магистрын ажил хамгаалсан зэрэг ажлын үр дүнгээр дээрх кредит цагийг жил бүр хувааж тооцно.

5. Эрдэм шинжилгээний бусад ажил

Хүснэгт 4.

1.	БХИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллах	3 кр.цаг
----	---	----------

2.	Докторантурын хорооны дарга, нарийн бичиг, гишүүнээр ажиллах	2.5 кр.цаг
3.	Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн болон сургалт, заах арга зүйн зөвлөлд гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллахад	1.5 кр.цаг
4.	Докторантурын хорооны гишүүн диссертац уншиж дүгнэлт гаргах	2.5 кр.цаг
5.	Судалгааны семинар, их семинар зохион байгуулах	Семинар бүрт 0.5 кр.цаг

Багшийн хөдөлмөрийн “В” цаг

Багшийн хөдөлмөрийн “В” цагт багшаас сургалтын ажил үйлчилгээний чанарт тавигдах стандартын шаардлагыг хангахад чиглэгдсэн **сургалт, заах арга зүйн** нэмэлт ажил, сонсогч /сурагч/ оюутныг хөгжүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ хамаарна.

Багшийн “В” цагт хамаарах ажил, үйлчилгээ

дд	Тооцох ажлын хэлбэр, үзүүлэлт	Олгогдох кредит /max/
1.	Багшаас хичээлд бэлтгэх: <ul style="list-style-type: none"> - 3 кредит цагтай хичээл бэлтгэж заахад - 2 кредит цагтай хичээл бэлтгэж заахад - 1 кредит цагтай хичээл бэлтгэж заахад - Шинэ хичээл бэлтгэж заахад тус тус олгох бөгөөд 5 хүртэл жил ажилласан багшид хоёр дахь баганы кредит цагийг, 5-аас дээш жил багшилсан бол эхний кредит цагийг олгоно.	1.0-1.5 кр.цаг 0.6-1.0 кр.цаг 0.3-0.5 кр.цаг 1.5-2.0 кр.цаг
2.	Нээлттэй, туршилтын, үзүүлэх хичээл заах	0.1 кр.цаг
3.	Багшийн хичээлд сууж зөвлөгөө өгөх /1 удаад/	0.05 кр.цаг
4.	Улирлын шалгалтын шалгагч багшаар ажиллахад <ul style="list-style-type: none"> - Аман хэлбэрээр сонсогч-оюутан тутамд - Сорил-тестийн хэлбэрээр сонсогч-оюутан. тутамд 	0.015 кр.цаг 0.005 кр.цаг
5.	Шалгалтын ассистент багшаар ажиллахад /шалгалт тутамд/	0.010 кр.цаг
8.	Багшаас сонсогч оюутны бие даалтыг тэнхимд удирдсан, зөвлөгөө өгөхөд 48 цаг тутамд олгох кредит цаг /ЭШСА, тэнхимээс гаргасан хуваарийн дагуу гүйцэтгэнэ/	1.0 кр.цаг
9.	Эчнээ, зайн сургалтын сонсогч, оюутны бие даалтын даалгаварт ажлыг шалгаж, хамгаалуулахад /хүн тус бүрт/	0.03 кр.цаг
10.	Явцын болон улирлын шалгалтын тест боловсруулах /тест бүрт/	0.2 кр.цаг
11.	Цахим лекц боловсруулах /CD, DVD-гээр лекц тус бүрт/	0.5 кр.цаг
12.	Тактик, тусгай тактикийн цогцолбор бодлого боловсруулахад /тус бүрт/	

	<ul style="list-style-type: none"> - Батальон салбарын түвшинд - Бригадын түвшинд - Армийн бүлгийн түвшинд 	<p>0.5 кр.цаг 0.8 кр.цаг 1.0 кр.цаг</p>
13.	ИӨҮАлбаар дамжуулан шалгалт авах хичээлийн улирлын шалгалтын иж бүрэн тест боловсруулахад	1.0 кр.цаг
14.	Хичээлийн хөтөлбөрт тусгагдсан тодорхой сэдвийг гүнзгийрүүлэн нэмэлт материал судалж сонсогч, оюутнаас бичсэн рефератыг уншиж үнэлэхэд	Реферат бүрт 0.05 кр.цаг
15.	Гадаад хэлний болон монгол хэлний хичээлийн гэрийн уншлага шалгахад /сонсогч, оюутан бүрт/	0.03 кр.цаг
16.	Багшаас заадаг хичээлийн дагуу тараах материал, кейс бэлтгэхэд /материал тус бүрт/	0.1 кр.цаг
17.	Мэргэжлийн дугуйланг тусгай батлагдсан хөтөлбөрийн дагуу удирдах	1.0 кр.цаг
18.	Оюутан, сонсогчыг батлагдсан сэдвийн дагуу тусгай хөтөлбөрөөр хичээллүүлсэн бол хүн бүрд	0.1 кр.цаг
19.	Багшаас хичээлийн иж бүрэн үзүүлэн хийж түүнийг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж баталсан бол /хичээл тус бүрт/	1.0 кр.цаг
20.	Лабораторийн ажлыг шинэчлэн өөрчилсөн бол /ажил тутамд/	0.5 кр.цаг
21.	Гарын авлага, фондын лекц, редакторласан, шүүмж бичсэн бол /ажил тутамд/	0.3 кр.цаг 0.1 /шүүмж/
22.	Мэргэжлийн болон үйлдвэрлэлийн /мэргэших/ дадлагын тайлан уншиж хамгаалуулсан багшид /сонсогч-оюутан тутамд/. Эчнээ сургалт хамаарна.	0.03 кр.цаг
23.	Сонсогч, оюутны улсын чанартай биеийн тамирын уралдаан тэмцээнд дасгалжуулж оруулсан багшид тухайн тэмцээнд үзүүлсэн амжилтаар кредит цаг тооцно. <ul style="list-style-type: none"> - Алтан медаль - Мөнгөн медаль - Хүрэл медаль - Шагналт байр 	<p>1.5 кр.цаг 1.0 кр.цаг 0.8 кр.цаг 0.5 кр.цаг</p>
24.	ЗХ-ний хэмжээнд зохион байгуулагдсан биеийн тамирын уралдаан тэмцээнд сонсогч оюутныг бэлтгэж оруулсан багшид <ul style="list-style-type: none"> - Алтан медаль - Мөнгөн медаль - Хүрэл медаль 	<p>1.0 кр.цаг 0.8 кр.цаг 0.6 кр.цаг</p>
25.	ЗХ-ний марш тактикийн тэмцээнд салаа, тасаг удирдан зохион байгуулж оруулсан багш нарт /тухайн кредитийг хувааж тооцно/. <ul style="list-style-type: none"> - Алтан медаль - Мөнгөн медаль - Хүрэл медаль 	<p>4.0 кр.цаг 3.0 кр.цаг 2.0 кр.цаг</p>
26.	Лаборатори, тусгай тоноглогдсон танхим, кейс болон клиник сургалтын төв хариуцсан ажиллах	1.0 кр.цаг

27.	Сонсогч, оюутныг биеийн тамирын уралдаан тэмцээн, урлагийн үзлэгт зохион байгуулж оруулах /1 удаа/	0.5 кр.цаг
-----	--	------------

Гурав. Кредит цагаар хэмжигдэхгүй ажлын хөлс тооцож гүйцэтгүүлэх сургалтын ажил үйлчилгээ

Багш, хичээл заах эрх бүхий албан тушаалтан, сургуулийн сургалтын үйл ажиллагаанд оролцуулахаар дээд байгууллагаас болон БХИС-ийн захирлын тушаалаар томилогдсон хүмүүсийн тодорхой хичээлийн багц цагт оруулах боломжгүй сургалтын дараах ажил үйлчилгээ гүйцэтгэсэн хөлсийг цагаар тооцож тухай бүр нь олгоно.

Дд	Сургалтын ажил үйлчилгээний төрөл	Тооцох цаг
1.	Докторын хамгаалуулах зөвлөлийн дарга, орлогч нарийн бичгийн даргаар ажиллах	48 цаг
2.	Докторын хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллах	32 цаг /хүрэхгүй бол суусан цагаар/
3.	Бакалаврын дипломын болон төгсөлтийн ажил удирдаж хамгаалуулах /нэг багш 3-өөс илүү ажил удирдахгүй/	“А” – 40 цаг “В” – 32 цаг “С” – 24 цаг
4.	Бакалаврын болон төгсөлтийн ажилд шүүмж бичих /нэг багш 4-өөс илүү шүүмж бичихгүй/	Шүүмж бүрт 6 цаг
5.	Бакалаврын болон цэргийн мэргэжлийн төгсөлтийн шалгалтыг амаар, бичгээр авах, бакалаврын дипломын болон төгсөлтийн ажил хамгаалуулах /комиссын гишүүн бүрт/	20 хүртэл хүнтэй ангид 6 цаг 20-оос дээш хүнтэй ангид 8 цаг
6.	БХУА-ийн магистрын мэргэжлийн хичээлийн цогцолбор шалгалт авах /комиссын гишүүн бүрт/	8 цаг
7.	Магистрын мэргэжлийн хичээлийн шалгалт авсан комиссын гишүүн	10 хүртэл хүнтэй бол 3 цаг 10-20 хүний бүлэгт 6 цаг
8.	Докторын мэргэжлийн хичээлийн шалгалт авсан комиссын гишүүн	5 хүртэл хүнтэй бол 3 цаг 5-10 хүртэл 6 цаг
9.	Магистрын ерөнхий суурь хичээлийн шалгалт авсан комиссын гишүүн	10 хүртэл хүнтэй бол 3 цаг 10-20 хүнтэй бол 6 цаг
10.	Төгсөлтийн шалгалтын комиссын дарга, орлогч, нарийн бичгээр ажиллахад	Суусан цагаар
11.	Элсэлтийн шалгалтын комиссын гишүүнээр ажиллах /ажилласан өдөр бүр/	8 цаг
12.	Шинээр тавьсан лабораторийн ажлыг иж бүрэн болсны дараа хүлээн авч комиссын дүгнэлтийг үндэслэн хөлс тооцно.	Нэг ажилд 24-32 цаг /хөлсийг оролцсон багшид хувааж олгоно/
13.	Анги удирдсан багшаар ажиллах /ажлын үр дүнгээс хамруулан хүн нэг бүрээр сар бүр тооцож олгоно/	10000 төгрөг
14.	Хөгжмийн зэмсэгт засвар, үйлчилгээ хийх	Гэрээний дагуу хөлс тооцно.
15.	Зочин багш, салбарын тэргүүлэх эрдэмтэд, төр, нийгмийн зүтгэлтнээр лекц уншуулах	1 удаа 20000 төгрөг

16.	Мэргэжлийн, мэргэших дадлага удирдсан гадны байгууллагын мэргэжилтэн	Оюутан тутамд 10000 төгрөг
-----	--	----------------------------

Тайлбар: Сургалтын эдгээр ажил үйлчилгээнд олгогдох 1 цагийн хөлс нь тухайн **багшийн шатлалын 1 кредит илүү цагийн хөлсийг танхимийн 32 цагт хувааж гарсан мөнгөн дүнгээр тооцно.**

Дөрөв. Багшийн сургалтын ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцож, үнэлэх

4.1. Багшийн хичээлийн жилд гүйцэтгэх “А”, “Б” цагийн хэмжээг тэнхимийн дарга (эрхлэгч) нар багштай хамтран төлөвлөж СБЗА-аар хянуулж, БХИС-ийн Сургалт хариуцсан дэд захирлаар батлуулж мөрдөнө. “В” цагийг багш, төв, тэнхимийн дарга (эрхлэгч) нар хамтран төлөвлөж бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал, эрдэм шинжилгээ сургалтын албаны даргаар батлуулж хэрэгжүүлнэ.

4.2. Багш нь жилийн сургалтын ажлын нормыг **8** хүртэл кредит цагаар, бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, эрдэм шинжилгээ сургалтын албаны дарга **4**, төв, тэнхимийн дарга (эрхлэгч)-д **5** хүртэл кредит цагаар илүү гүйцэтгэж болох бөгөөд үүнийг багшийн ачааллын хэвийн норм гэж үзнэ. **Энэ хэмжээнээс илүү ачааллыг багшид төлөвлөж болохгүй.** Багшийн сургалтын ажлын жилийн үндсэн нормоос илүү гүйцэтгэсэн “А”, “Б” кредит цагт олгох илүү цагийн хөлсийг хичээлийн жилийн эцэст гүйцэтгэлээр нь тооцож багшийн ээлжийн амралтын өмнө олгоно. **Илүү цагийн хөлс тооцуулах багш нь “А”, “Б”, “В” цагийн үндсэн нормоо бүрэн биелүүлсэн байна.**

Багшийн 1 кредит цагийн үнэлгээ

Багшийн албан тушаалын шатлал	1 кредит цагийн хөлс
Профессор	88000
Дэд профессор	80000
Ахлах багш	72000
Багш	64000
Дадлагын багш	48000

Багшид илүү, дутуу цагийн хөлсийг дээрх жишгээр бодож олгох буюу хасна.

Тайлбар: Илүү цагт олгох хөлсний хэмжээг сургуулийн захирагааны зөвлөлөөр жил бүр багшийн албаны шатлал тогтоох асуудалтай нэгтгэн хэлэлцэж гарсан саналыг үндэслэн БХИС-ийн захирлын тушаалаар шинэчилж байна.

4.3. Багшийн гүйцэтгэсэн сургалтын ажлын “А”, “Б” цаг нь хооронд нь шилжүүлэн **тооцохгүй** бөгөөд илүү цагийн хэмжээ нь “А” цагт 8, “Б” цагт 4 кредит цагаас ихгүй байх зарчмыг мөрдөнө.

4.4. Мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн ЭШСА хичээлийн жилийн эцэст багш нарын сургалтын ажлын гүйцэтгэлийг дүгнэж СБЗА-аар хянуулж Сургалт хариуцсан дэд захирлаар батлуулна. Багшийн цагийн норм бүрэн биелсэн нөхцөлд ээлжийн амралтыг бүрэн эдэлнэ.

4.5. Багш тухайн хичээлийн жилд гүйцэтгэх сургалтын ажлаа хүндэтгэх бус шалтгаанаар биелүүлээгүй тохиолдолд **дутуу биелүүлсэн кредит цагийн хөлсийг амралтын хугацааны цалингаас суутгана.** Суутгалыг хийхдээ тухайн багш “А”, “Б”, “В” цагийн нийлбэр 1 сард 3 кредит цаг заавал гүйцэтгэсэн байхаар бодож уг тооцоог хийнэ.

4.6. Багш сургалтын ажил, үйлчилгээнээс гадна хичээлийн жилд гүйцэтгэх эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон сургууль, олон нийтэд үзүүлэх үйлчилгээгээ төлөвлөнө. Уг төлөвлөгөөг тэнхимийн дарга (эрхлэгч) баталж гүйцэтгэл, үр дүнд нь хяналт тавина. Багш хичээлийн жилийн эцэст өөрийн үнэлгээний тайлан бичиж мэргэжлийн тэнхимд тайлан хамгаалалт хийж ажлаа дүгнүүлнэ.

4.7. БХЯ, ЗХЖШ, сургуулийн удирдлагын шийдвэрээр өөр ажилд томилогдох, сургалтын ажлаас бусад ажил түр гүйцэтгэх, гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, сургалтанд хамрагдах, бүтээлийн болон захиргааны чөлөө авах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмсний, амаржсан зэрэг хүндэтгэх шалтгаантай хугацааг багшийн сургалтын ажлын нормоос тухайн чөлөөний хугацаанд ногдох кредит цагийг албан ёсны тодорхойлолт, баримтыг үндэслэн хасаж тооцно.

4.8. Гадаад хэлний тэнхимийн багш нарын захиалгат сургалтанд заасан хичээлийн кредит цагийг сургалтын ажлын үндсэн ачаалалд оруулж тооцохгүй.

Сургууль, тэнхим, багш захиалагч байгууллагатай харилцан тохирч ажлын хөлсийг гэрээгээр олгуулж байна.

Тав. Багшийн сургалтын ажлыг төлөвлөх, гүйцэтгэл, үр дүнг үнэлж тооцох эрх бүхий албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлага

5.1. Бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, эрдэм шинжилгээ сургалтын албаны дарга, мэргэжлийн тэнхимийн дарга (эрхлэгч)-д багш, тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн хичээлийн жилд гүйцэтгэх сургалт, эрдэм шинжилгээний ажлын нийт цагийг тухайн оны 5 дугаар сарын 15-ны дотор үнэн зөв тооцон гаргаж СБЗА болон ЭШДМСА-аар хянуулж Сургалт болон ЭШ хариуцсан дэд захирлуудаар батлуулж албажуулах үүрэг хүлээнэ. Сургалт, эрдэм шинжилгээний ажлын цагийг буруу төлөвлөх, гүйцэтгэлийг алдаатай тооцсон тэнхимийн дарга (эрхлэгч), бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, эрдэм шинжилгээ сургалтын албаны даргатай хариуцлага тооцно.

5.2. Мэргэжлийн тэнхимийн дарга (эрхлэгч)-д багш нарын сургалтын цагийг жигд хуваарилсан байх үүрэгтэй бөгөөд багш хүрэлцэхгүй, байхгүй нөхцөлд багшид “А” цагийн 4.2-т зааснаар илүү ноогдол хуваарилах буюу цагийн багшаар тухайн хичээлийг заалгаж болно.

Багшийн сургалтын цагийн ноогдлыг буруу тооцож хуваарилсны улмаас үүссэн маргааны хариуцлагыг тэнхимийн дарга (эрхлэгч) хүлээнэ.

5.3. Хичээлийн жилийн явцад ажлаас өөрчлөгдсөн, гадаад дотоод томилолтоор ажилласан, өвчилсөн зэрэг шалтгаантай багшийн хичээлийг СБЗА-ны зөвшөөрлөөр өөр багшид шилжүүлэн илүү цаг гүйцэтгүүлж болно.

Онцгой тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж багшаар илүү гарсан сургалтын ажил гүйцэтгүүлж болно.

5.4. Мэргэжлийн тэнхим хичээлийг хариуцан зохион байгуулах бөгөөд тэнхимийн дарга (эрхлэгч) багш нараас өөрийн тэнхим, сургуульд болон бусад тэнхимд заах хичээлийн ноогдлыг хуваарилж зохицуулна. БХИС-ийн бүрэлдэхүүний бусад сургуульд цагийн багшаар ажиллуулахыг хориглоно.

5.5. Багшийн сургалтын ажлын “А”, “В” цагийн гүйцэтгэлийг тэнхимийн дарга (эрхлэгч), бүрэлдэхүүн сургуулийн ЭШСА сар, улирал, жилээр тооцож, СБЗА хянаж, БХИС-ийн сургалт хариуцсан дэд захирлаар баталгаажуулснаар тооцно.

“Б” цаг буюу эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тэнхимийн дарга (эрхлэгч) бүрэлдэхүүн сургуулийн ЭШСА сар, улирал, жилээр тооцож, ЭШДМСА хянаж, эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал баталгаажуулснаар тооцно.

5.6.СБЗАлбаны болон ЭШМДСА-ны дарга нар бүрэлдэхүүн сургуулийн ЭШСА, мэргэжлийн тэнхимүүдийн сургалт эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлийн чанар, үр дүнг улирал, хичээлийн жилийн эхэнд, явцад, эцэст хянаж зохицуулах үүрэг хүлээнэ.

5.7.СБЗА, ЭШМДСА-ны дарга нар багш, мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургууль, магистр, докторын сургалтын хичээлийн жилд гүйцэтгэх сургалт, эрдэм шинжилгээний ажлын нийт багц цагийг сургуулийн хэмжээнд жил бүрийн 5 дугаар сарын 25-ны дотор нэгтгэн гаргаж БХИС-ийн захирлаар батлуулж байна.

5.8.БХИС-ийн захирлын баталсан сургалт, эрдэм шинжилгээний ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тулгуурлан шинэ хичээлийн жилд ажиллах багшийн орон тоо, илүү цагт болон цагийн багшид олгох ажлын хөлсийг тооцон гаргаж захирлаар батлуулан санхүүгийн албанд хүргүүлэх үүргийг СБЗА, ЭШМДСА хүлээнэ.

5.9. БХИС-ийн санхүүгийн албаны дарга-ерөнхий санхүүч нь сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын нэгдсэн төлөвлөгөөний А, Б, В цагийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн цагийн тооцооны дагуу багшийн гүйцэтгэх илүү цаг, сургалтын ажил үйлчилгээ гүйцэтгэхэд олгох болон цагийн багш нарт олгох ажлын хөлсийг дараа жилийн төсвийн төлөвлөлтөнд суулгаж байх үүрэг хүлээнэ.

Зургаа. Багшийн нэмэлт албан тушаал

БХИС-д үндсэн орон тооны багшийн албан тушаалаас гадна **зөвлөх профессор, багш, зочин багш**, цагийн багшийн албан тушаалууд байна.

6.1. Зөвлөх профессор, багшийн албан тушаалд БХИС-д он удаан жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, мэргэжлийн өндөр чадвартай, сургалт, заах арга зүйн арвин туршлагатай, эрдмийн цол, зэрэгтэй хүнийг бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн БХИС-ийн захирлын тушаалаар томилон ажиллуулна.

Зөвлөх профессор, багш нь БХИС-ийн багшийн үүрэгт ажлыг гүйцэтгэхээс гадна өөрийн **оюуны чадавхи, ажлын туршлага** өвлүүлэн үлдээх, **шавь багш бэлтгэх**, эрдэм шинжилгээ, төсөлт болон гэрээт ажил удирдах үүрэг хүлээнэ.

6.2. Хамтын ажиллагаатай гадаадын цэргийн их, дээд сургуулиас уригдан ирсэн багшийг зочин профессор, багшаар ажиллуулж болно.

6.3. Мэргэжлийн тэнхимд заагдах хичээлийн үндсэн норм нь багш нарын жилийн нормоос давсан, хичээлийн жилийн явцад багш чөлөө авсан, урт хугацаагаар томилолтоор явсан зэрэг тохиолдолд **цагийн багшийг** гэрээгээр ажиллуулна.

Цагийн багш нь БХИС-ийн багшид тавигдах нийтлэг шаардлагыг хангасан, багшлах дадлагатай, мэргэжлийн хүн байна. Цагийн багшийн гүйцэтгэсэн сургалтын ажлын хөлсийг БХИС-ийн багшид илүү цагийн хөлс тооцох журмын дагуу эрдмийн зэрэг, цолны байдлаар багшийн албан тушаалын шатлалд дүйцүүлэн кредит цагаар тооцож олгоно.

Сургалтын бодлого, зохицуулалтын алба Эрдэм шинжилгээ доктор, магистрын сургалтын алба